# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 26 өдөр          Дугаар 878          Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалт, 2023 оны 467, 468 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 200,988,325.00 (хоёр зуун сая есөн зуун наян найман мянга гурван зуун хорин тав) төгрөгийн балансын үнэ, 182,588,324.79 (нэг зуун наян хоёр сая таван зуун наян найман мянга гурван зуун хорин дөрвөн төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 12 тээврийн хэрэгсэл (11 автомашин, 1 механизм)-ийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26-ны
818 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, марк | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Балансын нийт үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Худалдах доод үнэ (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.433 дугаар хаалттай хорих анги | | | | | | | | | |
| 1 | Трактор /пад/ | 2009 | ш | 1 | 4,000,000.00 | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 500,000.00 |
| 2 | Пронтор /pronter, ачааны, 39-54 СЭА/ | 2001 | ш | 1 | 4,244,450.00 | 4,244,450.00 | 4,244,450.00 | - | 1,500,000.00 |
| Дүн | | | | 2 | | 8,244,450.00 | 8,244,450.00 | - | 2,000,000.00 |
| 2.Төв аймаг дахь ШШГГ | | | | | | | | | |
| 1 | Фургон -УАЗ /27-80ТӨА/ | 2014 | ш | 1 | 31,000,000.00 | 31,000,000.00 | 31,000,000.00 | - | 2,000,000.00 |
| Дүн | | | | 1 | | 31,000,000.00 | 31,000,000.00 | | 2,000,000.00 |
| 3.Дорнод аймаг дахь ШШГГ | | | | | | | | | |
| 1 | Фургон УАЗ, /33-90 ДОР/ | 2012 | ш | 1 | 20,640,000.00 | 20,640,000.00 | 20,640,000.00 | - | 2,000,000.00 |
| 2 | Карнивал /05-50 ДОУ/ | 2013 | ш | 1 | 35,000,000.00 | 35,000,000.00 | 35,000,000.00 | - | 2,500,000.00 |
| Дүн | | | | 2 | | 55,640,000.00 | 55,640,000.00 | - | 4,500,000.00 |
| 4.413 дугаар нээлттэй хаалттай хорих анги | | | | | | | | | |
| 1 | Зил-130 /59-25 СБА/ | 2009 | ш | 1 | 3,978,875.00 | 3,978,875.00 | 3,978,875.00 | | 1,000,000.00 |
| 2 | Пронтер /49-42СЭА/ | 2011 | ш | 1 | 8,500,000.00 | 8,500,000.00 | 8,500,000.00 | | 1,500,000.00 |
| 3 | Трактор /бага оврын/ | 2016 | ш | 1 | 5,000,000.00 | 5,000,000.00 | 5,000,000.00 | | 1,000,000.00 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Исузу вигхорн /27-56СЭН/ | 2008 | ш | 1 | 29,925,000.00 | 29,925,000.00 | 29,925,000.00 | | 2,500,000.00 |
| 5 | Чиргүүл /18-61УЧ/ | 2012 | ш | 1 | 5,000,000.00 | 5,000,000.00 | 5,000,000.00 | | 500,000.00 |
| 6 | Капатель төмс | 2012 | ш | 1 | 7,700,000.00 | 7,700,000.00 | 7,700,000.00 | | 500,000.00 |
| Дүн | | | | 6 | | 60,103,875.00 | 60,103,875.00 | | 7,000,000.00 |
| 5.405-р хаалттай хорих анги | | | | | | | | | |
| 1 | Ландкруйзер-100 | 2003 | ш | 1 | 46,000,000.00 | 46,000,000.00 | 27,599,999.79 | 18,400,000.21 | 18,500,000.00 |
| Дүн | | | | | | 46,000,000.00 | 27,599,999.79 | 18,400,000.21 | 18,500,000.00 |
| 12 | НИЙТ ДҮН | | | | | 200,988,325.00 | 182,588,324.79 | 18,400,000.21 | 34,000,000.00 |